



**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ**

**2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2022 ОН

ОРШИЛ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт зааснаар Зохицуулах Зөвлөл нь тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуурга /цаашид "УХАТ" гэх/-ын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй бөгөөд хуулийн 10 дугаар зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Зохицуулах Зөвлөл Монгол Улсад УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг үр ашигтай явуулах нөхцөл бололцоог бүрдүүлэн, дэлхийн жишигт нийцсэн чанар стандарт бүхий найдвартай, тэгш, хүртээмжтэй үйлчилгээг хот, суурины хэрэглэгчдэд хүргэх, баталгаажуулах оновчтой зохицуулалтыг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.

Нэг. Хуулийн хэрэгжилт

Үнэ, тарифын чиглэлээр

1.1. Хуулийн 10.1.1 дэх заалт буюу цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр тогтоох аргачлал, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчилгээний тарифыг хянаж батлах, нийтлэх ажлын хүрээнд:

1.1.1. Монгол Улсын 21 аймгийн сумдын ус түгээх байрны судалгааг хийж, нэгтгэн гаргав.

1.1.2. Архангай аймгийн Эрдэнэбулган сумын "Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ, Сэлэнгэ аймгийн Мандал сумын "Цант-Орхон" ОНӨААТҮГ, Завхан аймгийн "Амь-Ус" ХХК, Дархан-Уул аймгийн "Дархан ус суваг" ХК, Дорнод аймгийн "Дорнод НАА" ОНӨААТҮГ-ын-ын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг, мөн Булган, Сүхбаатар, Дорнод, Архангай, Хөвсгөл, Ховд, Завхан зэрэг 7 аймгийн 60 сумын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Үүнд:

- | | |
|-----------------------------------|----------------------------|
| • Булган аймгийн Гурванбулаг сум, | • Архангай аймгийн 17 сум, |
| • Сүхбаатар аймгийн 11 сум, | • Завхан аймгийн 5 сум, |
| • Дорнод аймгийн 5 сум, | • Хөвсгөл аймгийн 16 сум, |
| | • Ховд аймгийн 6 сум. |

1.1.3. 2022 онд доорх 36 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ирүүлсэн бөөний болон дамжин тарифын саналыг хянаж борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг баталсан. Үүнд:

- | | |
|--------------------------------|------------------------------|
| • "Цэцэн бээс" ХХК, | • "Ган инженеринг" ХХК, |
| • "Баянмонгол хотхон" ХХК, | • "Стандарт хийт" ХХК, |
| • "Комфорт Монгол нэтворк ХХК, | • "Таван өндөр" ХХК, |
| • "Гангар орд" ХХК, | • "Тунгалаг буянт дуут" ХХК, |
| • "Хүрд" ХК | • "Морьттүнгэ" ХХК, |
| • "Сод эгшиг" ХХК, | • "Хангай хотхон" ХХК, |
| • "Монхауз сервис" ХХК, | • "Эрчим скай стар" ХХК, |
| • "Нарантуул илч" ХХК, | • "Баянгазрын хишиг" ХХК, |
| • "Адтай ноён" ХХК, | • "Зүмбэр орд өргөө" ХХК, |
| | • "СТНАА" ХХК, |

- “Тохилог шинэ ертөнц” ХХК,
- “Трю эл менежмент” ХХК,
- “Жинст өргөө” ХХК,
- “Грийн проперти” ХХК,
- “Гурван оргил таун” ХХК,
- “Маршал комфорт” ХХК
- Арга мэргэн ХХК /бохир ус дамжуулах тариф/
- “Баатардулаан хан” ХХК,
- “Бадамлах нар” ХХК,
- “Богд-асар инженеринг” ХХК,
- “КСИМС” ХХК,
- “Хайспийд групп” ХХК,
- Ханжаргалант өргөө” ХХК,
- “Таункомфорт” ХХК,
- “МОНТС” ХХК,
- “Пюрхаус” ХХК,

1.1.4. 2022 оны байдлаар орон нутгийн НАА-н байгууллагуудын ажиллагсдын цалингийн дундаж судалгааг хийсэн.

1.1.5. Есөн аймагт шинэ цэвэрлэх байгууламж баригдсантай холбогдуулан НААҮ-ний байгууллагуудын УХАТ-ын зардал нөхөх төлөвлөгөөг боловсруулах тооцооллын маягт, санхүүгийн шинжилгээний маягт, зардал нөхөх төлөвлөгөөний төслийг боловсруулсан.

1.1.6. Хөдөө, орон нутгийн 52, Улаанбаатар хотын 81 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2023 оны борлуулалтын төлөвлөгөөг шалган нэгтгэж, зардлыг хянав.

1.1.7. Засгийн газрын 2020 оны 211-р тогтоолын хүрээнд үүссэн өр төлбөртэй Улаанбаатар хотын тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 76 ААН-тэй нэмэлт гэрээг хийн, төлбөр барагдуулах ажлын хүрээнд 7,282.9 сая төгрөгийн өр төлбөрөөс 2,142.8 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулж, 6 байгууллага бүрэн барагдуулж дууссан. Мөн 12 байгууллага өр төлбөрөө барагдуулаагүй байна. Тавиас дээш хувийн барагдуулалттай 7 тусгай зөвшөөрөл эзэмшигч байна.

1.2. Хуулийн 10.1.2 дахь заалт буюу үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийн хэмжээг тогтоох ажлын хүрээнд:

Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын 2021 оны элэгдлийн тайланг гаргаж, нэгтгэв. 2022 онд тарифын санал ирүүлсэн 38 байгууллагын үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг бүртгэсэн. Мөн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифын өртгөө нөхөх түвшинг тодорхойлж бүртгэл хөтлөв.

Тусгай зөвшөөрлийн чиглэлээр

1.3. Хуулийн 10.1.3 дахь заалт буюу Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох ажлын хүрээнд:

1.3.1. Орон нутгийн НАА-н дараах 11 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгаж баталсан. Үүнд:

- Ховд аймгийн НАА-н "Шим-Ус" ОНӨААТҮГ,
- Өвөрхангай аймгийн НААҮ-ний "Онги-Ус суваг" ОНӨААТҮГ,
- Өвөрхангай аймгийн "Хархорин Ус суваг" ХХК,
- Орхон аймгийн НААҮ-ний "Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ" ОНӨХК,
- Архангай аймгийн "Ар-Ус ундарга" ХХК,
- Говь-Алтай аймгийн "Ундарга-Алтай" ААТҮГ,
- Баянхонгор аймгийн "Чандмань Баянхонгор" ХК,
- Дорнод аймгийн "Дорнод НАА" ОНӨААТҮГ,
- Хөвсгөл аймгийн "Хөвсгөл ус суваг" ХХК,
- Өмнөговь аймгийн "Шугшаа-Уул" ХХК,
- Сүхбаатар аймгийн "Дөрвөлж" ОНӨААТҮГ.

1.3.2. Улаанбаатар хотын ОСНААҮ-ний дараах 34 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгаж баталсан. Үүнд:

- "Ханжаргалант өргөө" ХХК,
- "Таун комфорт" ХХК,
- "Тохилог шинэ ертөнц" ХХК,
- "Грийнпропери" ХХК,
- "Монватер" ХХК,
- "Пюрхаус" ХХК,
- "Хаусинг холд" ХХК,
- "Дай цэцэн" ХХК,
- "Эмпати хаус" ХХК,
- "Адтай ноён" ХХК,
- "Ганбиж" ХХК,
- "Богд Асар инженеринг" ХХК,
- "Цэнгэлдэх ОСНААК" ХХК,
- "Ди Ди прогресс" ХХК,
- "Монхауз сервис" ХХК,
- "Хүрээ хаус" ХХК,
- "Цэцэн бээс" ХХК,
- "Эс Жи Ливинг" ХХК,
- "Чандмань хүрд" ХХК,
- "Туул арвижих өргөө" ХХК,
- "Оч гялс өргөө" ХХК,
- "Баатардулаан хан" ХХК,
- "СТНАА" ХХК,
- "Бадамлах нар" ХХК,
- "Ган-Инженеринг" ХХК,
- "Хангай хотхон" ХХК,
- "Би Би инженеринг" ХХК,
- "Гурван оргил таун" ХХК,
- "Түмэн наяд хайрхан" ХХК,
- "Зүмбэр-Орд өргөө" ХХК,
- "Хүрд" ХК,
- "Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ,
- "Сод-Эгшиг" ХХК,
- "Хүрээ хаус" ХХК.

1.3.3. Бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээ, туршилт, тохируулгын, цэвэр усны үйлдвэр, бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ эрхлэх болон ангилал нэмүүлэх, нэр өөрчлүүлэх хүсэлт ирүүлсэн дараах 15 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгах, ангилал нэмэх асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд:

- "Ус био инженеринг" ХХК,
- "Комфорт импэкс" ХХК,
- "Байгууламж" ХХК,
- "ЧММ" ХХК
- "Ай Ди Эм Эн" ХХК,
- "Арцат шанх" ХХК,
- "Ар халхын нүүдэл" ХХК,
- "Витсамо фрукт жүүс" ХХК,
- "Цээз оргилуун" ХХК,
- "Өгөөж их бүрд" ХХК,
- "Сан гум" ХХК,
- "Дотоодын цэргийн 05 дугаар анги"
- "Галшинт" ХХК,
- "Алтай экокос" ХХК,
- "Вайз майнд солюшн" ХХК.

1.3.4. Нийтийн аж ахуйн ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр авах хүсэлт ирүүлсэн дараах 21 аж ахуйн нэгж, байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгосон. Үүнд:

- Архангай аймгийн "Эрдэнэмандал дэд бүтэц" ОНӨААТҮГ /орон нутгийн НААҮ-ний/;
- "Геодези, усны барилга, байгууламж" ОНӨААТҮГ /орон нутгийн ариутгах татуургын/;
- "Эн жи ай пропертиз" ХХК /ОСНААҮ-ний чиглэл/;
- "Ай ди эм эн" ХХК /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- "Грийн фантом" ХХК /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;

- "Олон нугалаа" ХХК /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- "Хурмаа хур" ХХК;
- "Ханхөхий хархираа түргэн" ХХК /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 421 дүгээр нээлттэй хорих анги" /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- "Түвшин төгөлдөр трейд" ХХК /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- "Шоомон бүрд" ХХК/ бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- "Эрчим трест" ХХК /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- "Элбэг ариун хөрс" ХХК /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- "Ган отгон" ХХК /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- Чингэлтэй дүүргийн бохир ус зөөврийн "Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв" УТҮГ /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- "Мандах ирээдүй манал" ХХК /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- "Грандпиглет" ХХК /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- "Ашид эрүүл хөрс" ХХК /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- "Плимут сириус" ХХК /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- "Ховдтул" ХХК /УХАТ-ын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга/;
- "Юу Би Эй констракшн" ХХК /УХАТ-ын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга/.

1.3.5. Нийтийн аж ахуйн ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүсэлт ирүүлсэн дараах 4 аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Үүнд:

- "Батзохиомж" ХХК /ОСНААҮ-ний чиглэл/;
- "Камдер" ХХК /ОСНААҮ-ний чиглэл/;
- "Юүлтүйнатурал" ХХК /ОСНААҮ-ний чиглэл/;
- "Цэцэн бээс" ХХК /ОСНААҮ-ний чиглэл/.

1.3.6. Мөн 2021 оны гэрээний биелэлт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг нь үндэслэн дараах 55 аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жилээр сунгасан. Үүнд:

- Аймаг, орон нутгийн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр Орхон аймгийн "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Улаанбаатар "Энержи интернэшнл" ХХК, Өмнөговь аймгийн "Паблик сервис" ХХК, Сэлэнгэ аймгийн "Мандал энерго" ОНӨААТҮГ, Өвөрхангай аймгийн "Онги ус суваг" ОНӨААТҮГ, Орхон аймгийн "Эрдэнэт ус ДТС" ОНӨХК, Хэнтий аймгийн "Хэнтий ус" ХХК, Өмнөговь аймгийн "Ухаа худаг ус хангамж" ХХК, Багануур дүүргийн "Багануур ус" ААТҮГ, Сэлэнгэ аймгийн "Спирт бал бурам" ХХК, Өмнөговь аймгийн

"Цог өрнөх" ОНӨААТҮГ, Төв аймгийн "Төв чандмань ДЭХГ" ОНӨААТҮГ, Дорнод аймгийн "Дорнод НАА" ОНӨААТҮГ, "УБТЗ" ХНН-ийн БАҮ-1-р анги, Говьсүмбэр аймгийн "Ус-Ду" ОНӨААТҮГ, "УБТЗ" ХНН-ийн "Эрчим хүч ус хангамжийн төв" МОХНН, Архангай аймгийн "Ар ус ундарга" ХХК, Баянхонгор аймгийн "Чандмань Баянхонгор" ХК, Өмнөговь аймгийн "Хан дизель" ХХК, Сэлэнгэ аймгийн "Цант-Орхон" ОНӨААТҮГ, Өмнөговь аймгийн "Гүний ус" ХХК, Улаанбаатар Налайх дүүргийн "Чандмань Налайх" ОНӨААТҮГ, Өвөрхангай аймгийн "Хархорин ус суваг" ОНӨААТҮГ, Говь-Алтай аймгийн "Ундарга-Алтай" ААТҮГ, Дархан-Уул аймгийн "Дархан ус суваг" ХК, "Дулаан шарын гол" ТӨХК, Булган аймгийн "Булган мээж" ХХК зэрэг 27 аж ахуйн нэгж, байгууллагуудыг 5 жилээр сунгалаа.

- Улаанбаатар хотын ОСНААҮ-ний "Баянмонгол хотхон" ХХК, "Опенхаус өнө" ХХК, "Чандмань хүрд" ХХК, "Гангар орд" ХХК, "Хүрээ хаус" ХХК, "Ханжаргалант өргөө" ХХК, "Ганбиж" ХХК, "Эрч хишиг" ХХК, "Богд асар инженеринг" ХХК, "Дунд мандал" ХХК, "Дай цэцэн" ХХК, "ОСНААҮГ" ОНӨААТҮГ, "Морьттүнгэ" ХХК, "Батбаян дулаан" ХХК, "Смарт план" ХХК, "Цэнгэлдэх ОСНААК" ХХК, "Оч гялс өргөө" ХХК, "Арга мэргэн" ХХК, "Таван өндөр" ХХК, "Туул арвижих өргөө" ХХК, "КСИМС" ХХК, "Тэлмүүн орд" ХХК, "Жинст өргөө" ХХК, "Эс Жи Ливинг" ХХК, "Бигкастел" ХХК, "Пюрхаус" ХХК, "Монватер" ХХК, "МОНТС" ХХК зэрэг 28 аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жилээр тус тус сунгалаа.

Тусгай зөвшөөрөл сунгуулах 112, тусгай зөвшөөрлийн ангилал шинээр нэмүүлэх 1, хүчингүй болгох 4, шинээр тусгай зөвшөөрөл хүссэн 21, нэр өөрчлүүлсэн 1, нийт 139 асуудлыг хууль тогтоомж болон тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хүрээнд шийдвэрлэв. Мөн Зохицуулах зөвлөлөөс гаргасан тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврыг тусгай зөвшөөрлийн гүйцэтгэлийн гэрээнд тусган, баталгаажуулав.

Тайлант хугацаанд шийдвэрлэсэн Нийтийн аж ахуйн ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нийт 139 асуудлын 14% нь шинээр олгосон, 82% нь сунгуулсан, 0.5% нь ангилал нэмүүлсэн, 0.5% нь нэр өөрчлүүлсэн, 3% нь хүчингүй болгуулсан үзүүлэлттэй байна.

Шинээр тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан болон ангилал нэмсэн асуудлыг хүснэгтээр харуулбал:


Хүснэгт 1

№	Тусгай зөвшөөрлийн нэр, төрөл	Шинээр олгосон	Сунгасан	Ангилал нэмүүлсэн	Хүчингүй болгосон	Нэр өөрчлүүлсэн
1.	Орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам, сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр	1	62		4	1
2.	Аймаг, орон нутгийн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр	2	37			

№	Тусгай зөвшөөрлийн нэр, төрөл	Шинээр олгосон	Сунгасан	Ангилал нэмүүлсэн	Хүчингүй болгосон	Нэр өөрчлүүлсэн
3.	Бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээний чиглэлээр	16	8			
4.	Цэвэрлэх байгууламжийг шинээр барьж, байгуулах болон туршилт, тохируулга хийх чиглэлээр	12	4	1		
5.	Цэвэр ус савлан борлуулах		1			
Нийт		21	112	1	4	1

Дээрх хүснэгтийг графикаар харуулбал:

График 1. Тусгай зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлэсэн байдал:



1.4. Хуулийн 10.1.4 заалт буюу Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах:

- 1.4.1 Архангай аймгийн “Ар ус ундарга” ХХК, Эрдэнэмандал сумын “Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ, Орхон аймгийн “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК, Улаанбаатар хотын ОСНААҮ-ний “Ханжаргалант өргөө” ХХК, “Таун комфорт” ХХК, “Тохилог шинэ ертөнц” ХХК, “Грийнпроперти” ХХК, “Монватер” ХХК, “Пюрхаус” ХХК, “Хаусинг холд” ХХК, “Дай цэцэн” ХХК, “Эмпати хаус” ХХК, “Адтай ноён” ХХК, “Ганбиж” ХХК, “Богд Асар инженеринг” ХХК, “Цэнгэлдэх ОСНААК” ХХК, “Хүрээ хаус” ХХК, “Цэцэн бээс” ХХК, “Эс Жи Ливинг” ХХК, “Чандмань хүрд” ХХК, “Туул арвижих өргөө” ХХК, “Оч гялс өргөө” ХХК, “Баатардулаан хан” ХХК, “Бадамлах нар” ХХК,

"СТНАА" ХХК, "Бадамлах нар" ХХК, "Хангай хотхон" ХХК, "Түмэн наяд хайрхан" ХХК, "Ган-Инженеринг" ХХК, "Би Би инженеринг" ХХК, "Гурван оргил таун" ХХК-иуд, тусгай зөвшөөрөл шинээр авахаар хүсэлт ирүүлсэн "Геодези, усны барилга, байгууламж" ОНӨААТҮГ, бохир усыг зөөвөрлөх "Сан гум" ХХК, "Ашид эрүүл хөрс" ХХК зэрэг 30 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа нь УХАТ-ын нөхцөл, шаардлага хангаж буй эсэхийг газар дээр нь шалгаж, үнэлгээ, дүгнэлт хийж, мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгсөн.

- 1.4.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч Ховд аймгийн "Шим-Ус" ОНӨААТҮГ, Увс аймгийн "Чандмань-Увс" ХХК, Баян-Өлгийн аймгийн "Суат" ХХК, Орхон аймгийн "Эрдэнэт ус ДТС" ОНӨХК, Сэлэнгэ аймгийн "Сэлэнгэ цэнгэг ус" ОНӨААТҮГ, Дархан-Уул аймгийн "Дархан ус суваг" ХК, Хөвсгөл аймгийн "Хөвсгөл-Ус суваг" ХХК, "Булган аймгийн "Булган мээж" ХХК, Өмнөговь аймгийн "Гүний ус" ХХК, Архангай аймгийн "Ар-Ус ундарга" ХХК, Дорнод аймгийн "Дорнод НАА" ОНӨААТҮГ, Дорноговь аймгийн "Чандмань Илч" ХХК зэрэг 12 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг батлагдсан удирдамжийн дагуу газар дээр нь хянаж, үнэлэлт дүгнэлт өгөв.
- 1.4.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн 2021 оны тайлан мэдээ, гэрээний биелэлтийг "Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг дүгнэх журам"-ын дагуу үнэлж, 2022 оны зорилтот түвшинг тодорхойлон, орон нутгийн болон Улаанбаатар хотын нийт 131 байгууллагууд холбогдох үүрэг, даалгаврыг албан бичгээр хүргүүлсэн.
- 1.2.1 Үйлчлэх хүрээнд нэмэлт болон өөрчлөлт оруулах хүсэлтийн хүрээнд давхардсан тоогоор нийт 50 гаруй аж ахуйн нэгж, байгууллага дээр очиж ажиллан, шугам сүлжээний тодруулгыг хийн, байр бүртгэлийн асуудлыг шийдвэрлэв. 2022 онд Улаанбаатар хотын хэмжээнд 166 орон сууцны барилга, 10328 айл өрх, 197 аж ахуйн нэгж, байгууллагыг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчлэх хүрээнд бүртгэсэн.
- 1.4.4 Монгол Улсын хэмжээнд 2022 оны 08 дугаар сарын 29-нд НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран зохион байгуулсан "Ариун цэврийн байгууламжийн хүртээмж" зөвлөлдөх уулзалтад оролцон, санал өгч ажилласан.
- 1.4.5 Зохицуулах зөвлөлийн даргын 2022.11.09-ний өдрийн 16/22 тоот хяналт шалгалтын удирдамжийн дагуу 2022 оны 11-р сарын 14-24-ний хооронд "ОСНААУГ" ОНӨААТҮГ-ын ХҮТ-үүдийн айл өрхийн болон ААНБ-ын цэвэр, бохир усны тоолуурын заалтын бичилт, борлуулалтын байцаагч болон ус хангамжийн инженерийн анхан шатны баримт, санхүүгийн холбогдох баримтууд, Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, ТЗНШ-ийн дагуу газар дээр нь шалган, дүгнэлт боловсруулан, холбогдох байгууллагад хүргүүлсэн.
- 1.4.6 Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2022 оны 01/795 тоот албан бичгийн дагуу Баянзүрх дүүргийн 26-р хороонд байх Мандала хотхоны хэрэгцээний халуун ус нь зэвтэй гарч байгаа тухай гомдлыг судалж, 2022.05.12-ны 01/339 тоот албан бичгээр хариу өгөв.

1.5.Хуулийн 10.1.5 заалт буюу Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх ажлын хүрээнд:

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 100 гаруй гомдол, маргааныг судалж, шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд зохион байгуулж, холбогдох тусгай зөвшөөрөл эзэмшигчид үүрэг, даалгаврыг өгч, гомдол, маргааныг шийдвэрлэсэн.

1.6. Тусгай зөвшөөрлийн журам, аргачлал, зааврыг боловсронгуй болгох, хууль, дүрэмд санал өгөх чиглэлээр:

- 1.6.1. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад нэмэлт, өөрчлөлт оруулан баталж, холбогдох нөлөөллийн шинжилгээ, судалгаа, дүгнэлтийн хамт ХЗДХЯ-д хүргүүлэн бүртгүүлсэн.
- 1.6.2. Засгийн газрын гишүүн болон аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд байгуулдаг Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2022 оны гэрээний хавсралтад оруулах саналыг БХБЯ-д хүргүүлсэн.
- 1.6.3. Техникийн нөхцөл олгох журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийг 2022 оны 6-р сарын 23-ны өдрийн 85 дугаар тогтоолоор баталж ХЗДХЯ-д хүргүүлэн бүртгүүлсэн.

1.7. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын улсын байцаагчийн ажлын хүрээнд:

- 1.7.1. Зохицуулах зөвлөлийн даргын баталсан 2022.11.02-ны өдрийн 14/22 тоот хяналт шалгалтын удирдамжийн дагуу 2022.11.03-14-ний хооронд тусгай зөвшөөрөл эзэмшигч “Жи Эй Би Өү Ти” ХХК, “Очгялс өргөө” ХХК, “Дэнж хотхон” ХХК, “Морьттүнгэ” ХХК, “Тунгалаг буянт дуут” ХХК, “Оч гялс өргөө” ХХК, “Бюлдинг мэйнтэнэнс” ХХК, “Булнайн ар” ХХК, “Ган-Инженеринг” ХХК, “Трю Эл менежмент” ХХК, “Хайспийд” ХХК, “Түмэн наяд” ХХК, “Өөдөө байгаль” ХХК, “Санкомфорт” ХХК-иудын үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хүрээнд явагдаж буй эсэх, хангагч байгууллагад үүссэн өр төлбөрийн талаар газар дээр нь очиж ажиллан, дүгнэлт гаргаж, зөвлөгөө мэдээллээр ханган, байцаагчийн албан шаардлагыг 8 газарт хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласан.
- 1.7.2. ХААИС нь ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж буй үйлдэлд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн боловч биелэлт хангагдаагүй тул ХУД-ийн Прокурорын газарт зөрчлийн хэрэг нээлгэн, зөрчил хянан шалгах ажиллагаа хийгдэж, илэрсэн зөрчлийг арилгуулсан.
- 1.7.3. Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддоржид 2022.05.12-ны 01/340 тоот “Цэвэр бохир усны инженерийн шугам, сүлжээний тухай” албан бичгээр зөвлөмж, Улсын байцаагчийн 01/22 тоот дүгнэлтийг хүргүүлж гомдол, маргаантай асуудлыг шийдвэрлэв.
- 1.7.4. Зохицуулах зөвлөлийн даргын баталсан 2022.09.19-ний өдрийн 11/22 тоот хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч “Жи Эй Би Өү Ти” ХХК-д хяналт шалгалт хийж, 2022.10.26-ны 01-01-125/04 тоот Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэв.
- 1.7.5. Улсын байцаагчийн зүгээс “Бадамлах нар” ХХК, “Монхауз сервис” ХХК, “Архангай аймгийн “Ар-Ус ундарга” ХХК-иудад тусгай зөвшөөрлийн хугацаагаа сунгуулах байцаагчийн албан шаардлагыг хүргүүлэн ажилласны үр дүнд зөрчлийг арилгуулан, тусгай зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлэв.

**Хоёр. Зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар
холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын төсөл боловсруулах
ажлын хүрээнд**

- 2.1. Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-ын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн чуулганаар хэлэлцүүлэн батлуулах бэлтгэл ажлыг хангасан.
- 2.2. Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсэгт ажиллаж, зардлын судалгааны тайланг боловсруулан гаргасан.
- 2.3. Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж хууль санаачлагчид хүргүүлсэн.
- 2.4. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 474 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ШУА-тай хамтран ажиллах санамж бичгийн дагуу Архангай, Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Өвөрхангай Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 156 сумын ундны усны чанарын судалгааны ажлыг хийж, нэгдсэн дүгнэлт зөвлөмжийн номыг бэлтгэн гаргасан.
- 2.5. НҮБ-ын Хүүхдийн Сантай ундны усны чанарын судалгааны ажлын үр дүн, хийх ажлын төлөвлөгөөг танилцуулсны дагуу Булган, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн ундны усны чанарын судалгааны санхүүжилтыг авсан бөгөөд санхүүжилтын зарцуулалтын тайланг хүргүүлсэн.
- 2.6. БХБЯ-ны дотоод аудитын зөвлөмжийн дагуу Зөвлөлийн даргын 2022.10.10-ны А/28 дугаар тушаалаар Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулсан.
- 2.7. Зохицуулах зөвлөлийн 2022 оны хуралдааны бэлтгэл ажлыг зохион байгуулж, нийт 188 тогтоол батлагдсаныг албажуулж, холбогдох тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт хүргүүлэв.
- 2.8. Зохицуулах зөвлөлийн даргын итгэмжлэлээр хууль сахиулах байгууллагад байгууллагыг төлөөлөх, хэрэг хянан шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөх, маргаан шийдвэрлэх ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг явуулав. Үүнд:
 - Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж байгаа Д.Энхзориг, С.Юмэнхүү, Л.Батмөнх нарын нэхэмжлэлтэй Зохицуулах зөвлөлд холбогдох захиргааны хэргийн шүүхэд хариу тайлбарыг гаргаж, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцсон.
 - БЗД-ийн ИХАШШ-ийн 2022.10.27-ны 5196 тоот албан хүсэлтийн дагуу холбогдох нотлох баримтыг бэлтгэж, Зохицуулах зөвлөлийн 2022.11.02-ны 01/648 тоотор хариу өгөв.
 - Нийслэл дэх ЗХАШ-ны шүүхийн 2022.11.29-ний 1/10252 тоот хүсэлтийн дагуу "Мөнх эвсэг" ХХК-ийн нэхэмжлэлтэй "УСУГ"-т холбогдох хэрэгт шинжээчээр ТЗХГ-ын мэргэжилтэн Д.Алтанбаганыг томилж, шинжээчийн дүгнэлтийг Зохицуулах зөвлөлийн 2022.12.13-ны 01/715 тоотор илгээсэн.
- 2.9. Байгууллагын дотоод мэдээлэлийн програмд нийт 1488 ирсэн албан бичиг, 725 явсан албан бичиг, 56 өргөдөл, гомдлыг оруулж, цахим архивын санг баяжуулав.

- 2.10. Иргэн, хуулийн этгээдтэй байгууллах 31 гэрээний төслийг боловсруулах, байгуулах, бүртгэх ажлыг хийв. Мөн Аудитын байгууллагын зөвлөмжийн дагуу "Гарьд дизайн" ХХК-тай байгуулах нэмэлт гэрээг боловсруулж байгуулав.
- 2.11. ДЭМБ-аас Монгол улсын хэмжээнд Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн өнөөгийн байдлыг судлах "GLAAS" судалгааны эцсийн хэлэлцүүлэгт оролцож, судалгааны тайланд санал өгсөн.
- 2.12. Орхон, Архангай аймгуудын "Усны аюулгүй байдлын төлөвлөгөө"-ний хэрэгжилтэд хөндлөнгийн аудит хийж, үнэлгээ, дүгнэлт өгсөн.
- 2.13. Архангай аймгийн Эрдэнэмандал, Тариат, Өндөр-Улаан сумуудын ус хангамжийн тогтолцоонд эрсдэлийн үнэлгээ хийж, "Усны аюулгүй байдлын төлөвлөгөө"-ний төсөл боловсруулж өгсөн.
- 2.14. ДЭМБ-ын суурин төлөөлөгч, АШУҮИС, УСУГ болон Зохицуулах зөвлөл хамтран "Ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөө, хэрэгжилтийг дэмжих" сургалтад илтгэл тавьж оролцсон.
- 2.15. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Улаанбаатар хотын ТЗЭ байгууллагуудтай гэрээтэй бохирдуулагч үйлдвэрүүдийн судалгааг нэгтгэж 2022.04.18-ны 01/226 тоотойр "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ болон БХБЯ-д хүргүүлсэн.
- 2.1. Засгийн газрын 211 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд үүссэн өр төлбөртэй УБ хотын ТЗЭ нийт 76 ААН-тэй нэмэлт гэрээг хийн, төлбөр барагдуулах ажлын хүрээнд 7,282.9 сая төгрөгийн өр төлбөрөөс 2,142.8 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулж, 6 байгууллага бүрэн барагдуулж дууссан. Мөн 12 байгууллага өр төлбөрөө барагдуулаагүй байна. Тавиас дээш хувийн барагдуулалттай 7 тусгай зөвшөөрөл эзэмшигч байна.

Гурав. Зөвлөлийн шийдвэр, үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх ажлын хүрээнд

- 3.1. Тусгай зөвшөөрөл, хэрэглэгчийн газрын дарга Г.Нарантуяа 2022 оны 3 дугаар сарын 22-нд Дэлхийн усны өдөртэй холбогдуулан Монгол Улсад үүссэн усны асуудал, тэр дундаа усны нөөц, ундарга, эх үүсвэрүүдийг хамгаалахтай холбогдуулан "Цэнхэр алт" хэлэлцүүлэг формд оролцож санал өгөв.
- 3.2. Дэлхийн усны өдрийг "Гүний ус, түүний үнэ цэнэ" сэдвийн хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран зохион байгуулж, тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас тайлан мэдээг авч нэгтгэв.
- 3.3. Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг "Хэрэглэгчээ сонсьё" нээлттэй өдөрлөгийн хүрээнд Улаанбаатар хотын ОСНААҮ-ний хувийн хэвшлийн болон орон нутгийн өмчит нийт 40 гаруй аж ахуйн нэгж, байгууллагуудыг уг өдөрлөгөөр хэрэглэгчиддээ үйл ажиллагаагаа сурталчилан таниулах үйл ажиллагааг зохион байгуулсан.
- 3.4. НҮБ-аас зохион байгуулсан Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийн хүрээнд Сүхбаатарын талбайд зохион байгуулсан өдөрлөгт байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан танилцуулга, гарын авлага материалыг бэлтгэн оролцов.
- 3.5. "ОСНААҮГ" ОНӨААТҮГ-аас зохион байгуулсан "Усаа хэмнэе" гэсэн уриан дор зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцон, хэлэлцүүлгээс гарах ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөнд санал өгсөн.

- 3.6. "Нийслэлийн усны тулгамдсан асуудал ба шийдэл 2022" хэлэлцүүлэгт 2022.04.22-нд оролцов.
- 3.7. "УСУГ" ОНӨААТҮГ-аас зохион байгуулсан "Усны эрэлтийн менежмент" сэдэвт хэлэлцүүлэгт санал өгч оролцсон.
- 3.8. ТХЗ-ийн хэрэгжилтийн талаар Сүхбаатарын талбайд 2022.09.10-ны өдөр болсон өдөрлөгийн мэдээллийг байгууллагын сайтад байршуулав.
- 3.9. Ус бохирдуулсны төлбөртэй холбоотой мэдээлэл, хүснэгтийг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагад хүргэн, цахимаар болон "УСУГ" ОНӨААТҮГ-ын мөн өөрийн байгууллагын сургалт судалгааны төвд хурлыг зохион байгуулсан.
- 3.10.** Зохицуулах зөвлөл нь 2022 оны байдлаар олон нийтийн телевизэд 36 удаа мэдээ, Радиод 7 удаа ярилцлага өгч 3 удаа шторк цацуулсан. Өдөр тутмын сонинд 3 удаа мэдээ мэдээлэл нийтлүүлсэн.

Дөрөв. Гадаад болон дотоод хамтын ажиллагааны хүрээнд

- 4.1. БХБЯ-аас 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан Нийтийн аж ахуйн удирдах ажилтнуудын уулзалт, семинарын ажлын хэсэгт ажиллах, бэлтгэл ажлын хүрээнд ТЗЭ байгууллагуудыг мэдээллээр ханган ажиллав.
- 4.2. "Азийн усны холбоо"-ны 2022 онд зохион байгуулагдсан "Азийн усны 2 дугаар долоо хоног" ээлжит болон ээлжит бус, удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус цахим хурлуудад оролцож Зохицуулах зөвлөлийн 2022 оны улирал бүрийн гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайланг хүргүүлсэн.
- 4.3. Бүгд Найрамдах Индонези улсын Бажо Лаун хотод зохиогдсон "Азийн усны холбоо"-ны удирдах зөвлөлийн 15 дугаар хурал, "Азийн олон улсын 7 хоног" үйл ажиллагаанд Зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь болон ЗУГ-ын дарга Б.Доржбат нарыг оролцуулах бэлтгэл ажлыг хангасан.
- 4.4. Дундговь аймгийн төвд баригдаж буй цэвэрлэх байгууламжийн хүний нөөцийг чадавхжуулах онолын сургалтыг 2022 оны 4-р сарын 11-22 хооронд, практик сургалтыг Өвөрхангай аймгийн "Онги ус суваг" ОНӨХХК-тай хамтран 2022 оны 5-р сарын 23-27-ны хооронд зохион байгуулав.
- 4.5. НҮБ-ын Хүүхдийн Сангийн "Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалд тэсвэртэй Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ" төслийн Зөвлөх хорооны ээлжит уулзалт болон төслийн хаалтын уулзалтад оролцсон.
- 4.6. Усны газарт шинээр хийж буй "Усны мэдээллийн нэгдсэн сан" байгуулах ажлын хэсгийн танилцуулгын хуралд 2022.09.16-нд оролцон, санал өгснөөс гадна өөрийн байгууллагын сургалт судалгааны төвд 8 байгууллагын төлөөлөл болох 24 хүн оролцсон уулзалтыг 2022.09.21-нд зохион байгуулсан.
- 4.7. БХБЯ-аас Нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын хариуцаж буй инженерийн байгууламж, үйл ажиллагааны судалгааг статистик судалгааны нэгдсэн мэдээллийг бүртгэх, ашиглах зорилгоор Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан тушаалын 6 болон 7-р хавсралтаар судалгааг гарган хүргүүлсэн.
- 4.8. "Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3388" төслийн хүрээнд Дундговь аймагт ашиглалтанд орсон шинэ цэвэрлэх байгууламжийн ажилтнуудыг чадавхижуулах онолын болон практик сургалтыг зохион байгуулсан.

- 4.9. “Монгол Улсын ундны усны чанарын судалгааны үр дүнг хэлэлцэх нь” сэдэвт уулзалт зөвлөгөөнийг Зохицуулах зөвлөлийн Даргын 2022 оны 11 сарын 25-ны өдрийн А/32 дугаар тушаалын дагуу 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Millenium Плазагийн хурлын танхимд зохион байгуулсан.
- 4.10. Улсын Их Хурлын гишүүдэд тус бүрийн тойрогт хамааралтай аймаг, дүүргийн ундны усны чанарын судалгааны тайлангийн ном, хураангуй тайланг албан бичгийн хамт хүргүүлсэн.
- 4.11. Нийтийн аж ахуйн үйлчилгээний талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны асуумжийг “ОСНААУГ”-ын ХҮТ-ээс авах ажлыг зохион байгуулсан.
- 4.12. Есөн аймагт шинэ цэвэрлэх байгууламж баригдсантай холбогдуулан НАА байгууллагын зардал нөхөх төлөвлөгөөний төслийг боловсруулав.
- 4.13. Монгол Улсын төв, суурин газрын ундны усны чанарын судалгааны нэгдсэн товчоо тайлангийн номын эхийг боловсруулан хэвлүүлэв.

**Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын
ашиглалт, үйылчилгээг зохицуулах зөвлөл**